

# Living the Lotus 6

2024  
VOL. 225

*Buddhism in Everyday Life*



**Хойд Калифорни мужийн “Cherry Blossom Festival”  
РКК Хойд Америкын гишүүд Сан-Франциско хотод  
болсон баярын жагсаалд оролцов**

**Living the Lotus  
Vol. 225 (2024.06)**

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*





## Сэтгэл амгалан, тайван амьдрах

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### “Ийн амьдрахсан”

Бороонд угаагдсан ногоон навчис нүд булаах зуны улирал мөдхөн ирлээ. Ус чийг ихсэж, агаарын хэм дулаарах борооны улиралд сэтгэл санаа хүртэл нэвт норж, өөрийн эрхгүй ганцаардан гуниглах үе байдаг. Ийм үед ядаж сэтгэл өөдрөг тэнэгэр байхыг хичээвэл зохилтой.

Саяхан маш сайхан шүлгийн түүвэр олж уншсан. Яруу найрагч Таникава Шүнтароо гуай англи хэл дээрх “Дармапада” судрын эшлэлүүдээс сэтгэлдээ шингэсэн эшлэлийг япон хэлээр найруулан бичсэн ном байсан. Тэдгээрээс нэгийг нь та бүхэнд танилцуулъя.

#### Амгалан бай

Зугаа цэнгэл хөөвөөс зөвхөн уйтгар гуниг үлдэнэ  
Зугаа цэнгэлд ташуурваас зовлонгоос үл хагацана  
Алдах зүйлгүй сэтгэл аз жаргалаар дүүрнэ  
Агсам зан нүдийг харанхуйж, сэтгэлийг түгжинэ  
Ааг омог биеийг хүлж, сэтгэлийг боомилно  
Амгалан бай сэтгэл минь  
Аядуу тайван, уян зөөлөн, уудам тэнэгэр бай

«Эрүүл, амгалан, уян зөөлөн бай» (Коосэй хэвлэлийн газар, 2006)

Номын хавтас дээр “Ийн амьдрахсан” гэж бичсэн байсан ба би ч бас яг л тэгж бодсон. Амар амгалан, уужуу тайван, уян зөөлөн бас эрүүл байхсан гэж. Ийн амьдрах юм бол сэтгэл санаа үнэхээрийн хэзээд өөдрөг тэнэгэр байж, баригдах зүйл, харуусал гуниг, гаслан зовлон үгүй амар амгалан өдрүүдийг өнгөрүүлэх нь дамжиггүй.



Шагжамүни бурхан амар амгаланд хүргэх зүйл бол “бурхны номд хичээх явдал” гэж сургасан. Бурхны номд хичээснээр амар амгалан өдрүүдийг өнгөрүүлэх боломжтой гэж ойлгож болно. Тэгвэл бурхны номд хичээх гэдэг нь чухам юу гэсэн үг юм бол?

## Өсөж хөгжих хүсэл эрмэлзэл байвал

Бурхны сургаал “оройгүй сургаал” гэгддэг ба үүнээс дээд зүйл үгүй гайхамшигт сургаал ч гэж ойлгож болно. Бид энэ сургаалд зөвхөн талархан мөргөх бус хичнээн сурсан ч хязгааргүй сургаал хэмээн хүлээн авч, бодь сэтгэлээ хөгжүүлэхийн зэрэгцээ сурсан зүйлээ өдөр тутамдаа хэрэгжүүлэх чухал. Биднийг амар амгаланд хөтлөх хичээл зүтгэл гэж үүнийг хэлнэ гэж бодож байна.

Шашны сургаалыг биеэрээ бодитоор хэрэгжүүлж гэмээнэ утга учир нь гарч ирдэг тул өдөр тутмын үйл хөдлөл болгондоо эелдэг сайхан сэтгэл, өөдрөг гэгээлэг, зөөлөн дулаан харилцаа зэрэг сурсан сургаалаа хэрэгжүүлэх нь зүй. Хором мөч бүрт ийнхүү бурхны номд хичээснээр өдөр бүр сэтгэл амар амгалан байна.

“Сурсан сургаалаа хэрэгжүүлэх” гэхээр алийг нь сонгон авч хэрэгжүүлбэл зохих юм бол гэж эргэлзэх хүн байж магадгүй. Ямар хүнийг үлгэр дууриалаа болгодог, яаж амьдрахыг хүсдэг, ямар хүн байхыг хүсдэг зэрэг тухайн хүний хүсэл эрмэлзлэлээс шалтгаалаад бурхны номыг олон янзаар хэрэгжүүлж болно гэж бодож байна.

Жишээлбэл өөрт оноогдсон үүргээ биелүүлэн эрүүл мэнддээ анхаарах нь өглөгийн үйл (биеэр үйлдэх өглөг) болох ба бусдад төвөг удахгүй амьдрах боломжгүй ч аль болох төвөг удахгүй байхыг чандлан хичээх нь ч гэсэн бурхны номыг хэрэгжүүлж буй нэг хэлбэр юм. Ажил алба төдийгүй хоол унд хийх, юм угаах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг ар гэрийн ажлаа хүртэл үргэлж баярлаж талархсан сэтгэлээр хийх нь мундаг бурхны үйл болно. Өөрөөр хэлбэл өсөж хөгжихийн төлөөх хүсэл эрмэлзэлтэй байж, түүнийхээ дагуу амьдрах нь бурхны үйл болох ба баяр баясал, амар амгалан эндээс урган гарч ирдэг болов уу.

Гэхдээ сэтгэл санаа бүүдгэр өдөр ч тохиох биз ээ. Тийм үед хэрэг болох Тоои Ёшио ламтны бичсэн энэ улиралд яг тохирсон “Бороо орсон ч бүү үглэж гомдолло. Бороотой өдөр бороотой өдөрт тохирсон амьдрал бий.” хэмээх эшлэл бий. Ундуйцал дургүйцэл төрсөн үедээ энэхүү эшлэлийг санаж, харин ч бүр өөдрөг тэнэгэр байхыг хичээх гэсэн бурхны үйлийг хэрэгжүүлээд үзвэл ямар вэ? Тэр өдөр амар амгалан, сайхан өдөр болно гэдэгт эргэлзэхгүй байна.





# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Шинэхэн гишүүн танаа

### Өвөг дээдсээ дээдлэх нь

Гүнгэрваан дахь ургийн сахиусанд бүх өвөг дээдсээ тахих, нийгэмлэгийн гишүүн хүн ямар байх ёстой, бурхны зам мөрийн зорилго, арга замын талаар тусгасан байдаг. Хүн бүрт зөвхөн өөрийн аав ээж төдийгүй эцэг эхийн эцэг эх, тэдний эцэг эх гэх мэтчилэн маш олон өвөг

дээдэс бий. Тэд бүгдийн ачаар өнөөдрийн бид байгаа билээ. Бид ч мөн хэзээ нэгэн цагт өвөг дээдэс болно. Хүний амь амьдрал ингэж үргэлжилсээр байдаг. Бид өнөөдөр ийнхүү амьд байгаа нь үнэхээрийн гайхамшигтай зүйл билээ.



\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





Сургаалыг дамжуулах  
(номын мөрд хөтлөх)



Бурхны сургаал түгэн дэлгэрч, хэрэгжүүлдэг хүмүүс нэмэгдэхийн хэрээр аз жаргалтай хүмүүс ч нэмэгдэж нийгэм гэрэл гэгээтэй болох билээ. Үүний төлөө сургаалыг дамжуулж, сургаалын дагуу амьдрахыг уриалах нь “номын мөрд хөтлөх” үйл юм.

Мөн сургаалын талаар хүмүүст ярьж өгснөөр өөрөө сайн ойлгоогүй зүйлээ олж харахаас гадна Бурханы хүсэл, үйлчлэлийг олж анзаардаг. “Номын мөрд хөтлөх” үйл нь хүмүүсийг зөв замд чиглүүлж, гэрэл гэгээтэй ертөнцийг бий болгох эрхэм үйл хэрэг бөгөөд өөрөө ч мөн сургаалыг ойлгож, өсөж хөгжих чухал дадлага болдог.





## Нутаг орныхоо ачийг хариулахын төлөө

Акагава Кэйичи

Бүгдээрээ сайн байцгаана уу?

Сэрүүн тунгалаг зун цаг ирж байгаа энэ үед би салхинд найгах моддыг ажиглангаа байгаль ертөнцийн амьд оршихуйн хэмнэлийг мэдэрч байна.

Нивано ерөнхийлөгч 1 сарын айлдвартаа өөрийнхөө бичсэн “Бодь сэтгэлийг хөгжүүлэх” номынхоо тухай дурдаж, амар амгаланд хүрэхийн тулд “Шагжамүни бурхны дамжуулахыг хүссэн сургаалыг энгийнээр хүлээн авч, өдөр тутмын амьдралдаа хүчлэлгүйгээр хэрэгжүүлэх” чухал гэж сургасан. Харин энэ сарын айлдвартаа тэрээр юуг хэрэгжүүлэхээ мэдэхгүй байгаа хүмүүст “Ингэж амьдрахсан” гэсэн “хүсэл эрмэлзэл” -тэй байхад ямар бурхны үйлийг хэрэгжүүлэх хэрэгтэй нь тодорхой болно гэж зөвлөжээ.

Энэ хавар би оршин суугчдын холбооны хүсэлтээр амьдардаг хорооныхоо хэсгийн ахлагч болсон юм. Энэ үүрэг бол холбооны хураамжийг цуглуулахаас эхлээд тогтмол уулзалт, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, орон нутгийн нийгэм соёлд хувь нэмрээ оруулсан хүнийг тодруулж алдаршуулах зэрэг чухал үүргийг гүйцэтгэдэг. Манайх энэ нутагт амьдарч эхлээд 20 жил өнгөрчээ. Холбооны шинэ гишүүд биднийг хүлээн авч, итгэл хүлээлгэсэн нутгийн иргэддээ болон өдийг хүртэл амар амгалан амьдарч ирсэндээ талархсан талархалаа би хэсгийн ахлагчийн ажил үүргээр дамжуулан илэрхийлэх боломж олдлоо гэж бодож байна. Янз бүрийн асуудал бэрхшээл тулгарч магадгүй хэдий ч орон нутгийнхаа ачийг хариулахсан гэсэн “хүсэл эрмэлзэл”-тэй болсноор харах өнцөг маань илүү өргөжин тэлж байгааг мэдэрч байна. Амьдрал улам сонирхолтой болж байна шүү.



2024 оны 4 сарын 8. Нэг хөлгөний эрдэнийн суваргын өмнө  
Бурхан багшийн мэндэлсэн өдрийн ёслолд оролцсон гишүүдийн хамт  
(Акагава дарга урд эгнээний зүүн талаас 3 дахь нь)




# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)